



ӨНӨӨДӨР СОНИНЫ ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧ
БАЛДОРЖИЙН НАНДИНТҮШИГ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хуульчдын гудамж 13/1, Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2015. 10. 13 № 1/2231.

танай _____-ны № _____-т

Олон нийтэд үнэн зөв
мэдээлэл өгөх тухай

Нийгмийн даатгалын салбарын хамт олон жилд улсын нэгдсэн төсвийн орлогын ¼ хувьтай тэнцэх хэмжээний орлого бүрдүүлж, мөн хэмжээний тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээг санхүүжилж ирсэн билээ.

Танай сонинд нийтлэгдсэн “Нас барагсадыг амьдруулах “шидтэн”-үүд нийгмийн даатгалд одоо ч байна” нэртэй нийтлэлд нийгмийн даатгалын байгууллагын болон арилжааны банкны ажилтнууд хамтран нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн мөнгийг ямарч хяналтгүйгээр зарцуулдаг мэтээр үндэслэлгүй мэдээлэл олон нийтэд тарааж байна.

Энэ нь нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчид хүргэх, нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх үүрэг хүлээн ажиллаж буй тус салбарын ажилтнуудын төсвийн орлого бүрдүүлэх ажилд бэрхшээл учруулах хор уршигтай юм.

Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд Төрийн аудит, Мэргэжлийн хяналтын байгууллага болон Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын хөндлөнгийн болон дотоодын хяналт шалгалтыг жил бүр хийж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр нь арилган залруулж, холбогдох хариуцлагыг тооцож ирсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэртэй давхардуулан олгох, тэтгэврийн нэр төрлийн давхардуулан олгох, нас барсны дараа нь гэр бүлийн гишүүд нь мэдэгдээгүйгээс үргэлжлүүлэн олгож байгаа эсэхийг шалган баталгаажуулах ажлыг 2013-2015 онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын шийдвэрээр “Тэтгэврийн нэгдсэн хяналтыг сайжруулах” арга хэмжээг зохион байгуулан ажиллаж ирэв. Эдгээр шалгалтаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр авч байсан иргэн нас барсан тохиолдолд нас барсны дараагийн сарын тэтгэврийг тэдний ар гэрт олгосоноос хойш үргэлжлүүлэн олгосон 148 хүнтэй холбоотой 164,9 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлж, 2015 оны 10 сарын 01-ний өдрийн байдлаар нийт төлбөрийн 70.0 хувь буюу 114,7 сая төгрөгийн төлбөр, зөрчлийг бүрэн барагдуулсан ба төлбөр зөрчлөөс тэтгэвэр авагчийн банкны зээлэнд суутгагдсан 26,4 сая төгрөгийн зөрчлийг барагдуулахаар ажиллаж байна.

Мөн Нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтаар 101 иргэн нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн халамжийн сангийн тэтгэврийг давхардуулан авч байсан зөрчлийг илрүүлж, таслан зогсоосон юм.

Даатгуулагч, ажил олгогчдынхоо итгэл найдварыг хүлээх замаар нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй, буруу ташаа мэдээллийг олон нийтэд хүргэж, төөрөгдүүлэхгүй байхыг шаардаж байна.

ДАРГА




Ц.УРТНАСАН